



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 724

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэн  
үнийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 2, дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Дархан-Уул аймаг дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 60,216,310.00 (жаран сая хоёр зуун арван зургаан мянга гурван зуун арван) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглах хугацааг сунгаж, үнийг 2,000,000.00 (хоёр сая) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоож, Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Дархан-Уул аймаг дахь Гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Цэндсүрэн, Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга Н.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007186  
35-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн  
7.2.21..... дүгээр тогтоолын хавсралт



Дархан-Уул аймаг дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй Булган аймгийн Хөдөлмөр, хalamжийн үйлчилгээний  
хэлтэст балансаас балансад шилжүүлэх автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ, хуrimтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)
1	Ландкруйзэр-105, 00-09 ДАХ, арал№ JTECB09J853019030	2007/ 2007	155,5	60,216,310.00	2,000,000.00	1
	Нийт дүн			60,216,310.00 (жаран сая хоёр зуун арван зургаан мянга турван зуун арван)	2,000,000.00 (хоёр сая)	